

ЭЛЕКТРОН МЭДЭЭЛЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ:
ЭЭРЭГ БА СӨРӨГ ХАНДЛАГА

Г Солонго*

* «Идэр» дээд сургуулийн багш, МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхмийн магистрант

Түлхүүр үг: хэвлэл мэдээлэл, электрон мэдээлэл, интернет, мэдээллийн хамгаалалт, мэдээллийн нийгэм дэх орчны зөрчил.

Мэдээлэл нь хүний амьдралын салшгүй нэг хэсэг бөгөөд бидний оршин буй үеийг мэдээллийн зуун гэсэх нь санамсаргүй хэрэг биш юм. Түүхийн үүднээс аваад үзсэн ч монголчуудын дунд мэдээлэл онцгой байр суурь эзэлсээр ирсэн. Үүний илрэл нь нүүдэлчид сураг чимээ буюу мэдээллийг ашиглаж байсан ба манайд анхны морин өртөөг тэртээ XIII зууны үед байгуулсан билээ. Мэдээллийг хамгийн боловсронгуй бөгөөд шуурхай дамжуулах арга нь тухайн үедээ дээрх хэлбэр байжээ. Тэгвэл өнөө үед шинжлэх ухаан хөгжиж, радио, телевиз, утас, компьютер гэх мэт дэвшилтэт технологи гарч ирж, тухайн мэдээллийг цахилгаан соронзон долгионы хурдаар дамжуулж, хормын дотор дэлхийн аль ч алслагдсан цэгт хүргэх боломж бүрдсэн. Өөрөөр хэлбэл компьютерийн тусламжтайгаар сүлжээ ашиглан өөр хоорондоо өгөгдөл дамжуулдаг болсноор мэдээлэл түгээх,

хүлээн авахад хувьсал гарсан гэж хэлж болох юм. Энэхүү компьютерийн сүлжээнд хиймэл дагуулыг ашиглан холбогдох болсон интернетийг анх АНУ-ын Батлан хамгаалах яам цэрэг дайны зориулалтаар үүсгэснийг өдгөө хүн бүр мэддэг. Өнөөдөр хөгжингүй орнуудын ихэнх хүний амьдралын салшгүй нэг хэсэг нь интернет болоод байна. Зөв мэдээлэл бол ач тустай шийдвэр гаргахад нөлөөлдөг хамгийн том хүчин зүйл билээ. Тийм ч учраас интернетийн давуу талыг тоочоод дуусахгүй. Технологийн энэ хөгжил, сэтгүүл зүйн нэг хэлбэр болох электрон мэдээлэл хүлээн авах, дамжуулах үйл явц манай орны хувьд ямар төвшинд байгаа, эерэг болон сөрөг талууд нь юу байж болохыг илтгэлдээ тусгалаа.

1. Мэдээллийн дэд бүтэц

1.1. Ном сурах бичиг, номын сан. Монголчуудын хувьд мэдээлэл дамжуулах, түүнийгээ хадгалах анхны хэлбэр нь сураг чимээ, аман ярианаас гадна ном байжээ. Улсын төв номын сангаас 2000 онд гаргасан үзүүлэлтэд манай улсын хэмжээнд нийт 888 номын

сан ажиллаж байгаагийн 69 хувь нь сургуулийн, 20 хувь нь нийтийн, 5 хувь нь төрийн байгууллагын, 4 хувь нь их дээд сургуулийн, үлдсэн нь бусад төрлийн номын сан байна. Түүнчлэн Монгол улсын хэмжээнд 1999 онд 3 сая ном хэвлэгдэн гарснаас 1,5 сая нь Ерөнхий боловсролын сургуулийн ном, сурах бичиг байжээ¹.

1.2. Хэвлэл мэдээлэл. Монгол улсын Засгийн газрын шийдвэрийн дагуу өнөөдрийн байдлаар мэдээллийн бүх хэрэгсэл Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлдэг бөгөөд 2002 оны 12-р сарын 31-ний байдлаар 1158 сонин, 273 сэтгүүл, 127 радио, телевизийн студи, нийт 1558 ХМХ бүртгүүлснээс 175 сонин, 48 сэтгүүл, 37 радио, 23 телевизийн студи, 14 кабелийн үйлчилгээний телевиз үйл ажиллагаагаа тогтвортой явуулж байна². Түүнчлэн мөн оны байдлаар манай оронд хэвлэл мэдээллийн чиглэлээр 75 төрийн бус байгууллага³ үйл ажиллагаа явуулж байгаагаас агуулгын тал дээр Монголын хэвлэлийн хүрээлэн, Монголын чөлөөт хэвлэн нийтлэгчдийн холбоо, «Дөрвдэх хүч», Монголын чөлөөт сонины холбоо, Монголын зохиолчдын эвлэл, Монголын ном хэвлэн нийтлэгчдийн холбоо зэрэг байгууллага анхааран ажилладаг. Өдөр тутмын найман сонин ("Үнэн" 1920, "Өнөөдөр" 1996, "Монголын мэдээ" 1998, "Өдрийн сонин" 1999, "Зууны мэдээ" 1999, "Ардын эрх" 2004, "Өнөөдрийн Монгол" 2005, "Улаанбаатар таймс") хэвлэгдэж улс орон даяар болон хилийн чанадад түгээгдэж байгаа. Үүнээс гадна 15 сонин гадаад хэл дээр хэвлэгдэж, 33 сонин электрон хувилбартай байна. Монголын үндэсний телевиз, Улаанбаатар Брод-

кастинг, TV-5, TV-9, 25-р суваг телевиз, Сансар кабелийн телевиз, "Eagle" үйл ажиллагаагаа тогтвортой явуулж байна. Орон нутгийн телевизүүд зөвхөн аймгийн төвд нэвтрүүлгээ цацдаг. Агуулгын хувьд гэвэл орон нутгийн мэдээлэл, жүжиг, кино, бусад уран сайхны нэвтрүүлэг зонхилдог байна.

Харин 2002 оны байдлаар улсын хэмжээнд 37 радио станц үйл ажиллагаа явуулж байгаагийн 26 нь богино долгионы FM радио юм. Үндэсний хэмжээнд Монголын радио 7 хоногт 126 цаг, Улаанбаатар радио 7 хоногт 18-168 цаг, орон нутгийн радио 7 хоногт 2-126 цагийн нэвтрүүлэг явуулдаг байна. Нийт 5 радио интернетэд вэбээ байрлуулж, 2 радио интернетээр нэвтрүүлгээ цацдаг байна⁴.

1.3. Электрон мэдээлэл. Сүүлийн арваад жил Монголд сэтгүүл зүйн мэдээлэл түгээх хамгийн шуурхай хэлбэр гэж хэлж болох электрон мэдээлэл эрчимтэй хөгжиж байна. Өөрөөр хэлбэл мэдээллийг электрон хэлбэрээр хадгалах, түгээх, солилцох болон цаасан хэлбэрт байгаа мэдээллийг электрон хэлбэрт хөрвүүлэхэд ХМХ-үүд ихээхэн анхаарч байна. Тухайлбал, монголд гарч байгаа сонины тоймыг www.sonin.mn, www.oloo.mn сайтаас уншиж болох ба www.mongolmedia.com-д хандан захиалах боломжтой гэх мэт.

II. Электрон мэдээллийн өнөөгийн байдал

Өнөөдөр мэдээллийн агуулгын хүрээнд Монгол улсын Хэвлэлийн эрх чөлөөний хууль (1998), Зохиогчийн

эрхийн тухай (1993) зэрэг бие даасан хууль болон бусад хуулийн заалт мөрдөгдөж, мэдээллийн аюулгүй байдлын тухай асуудал хэлэлцэгдэж байна. Монгол Улсын Үндсэн хуульд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулах зорилготой Хэвлэлийн эрх чөлөөний хууль нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах, мэдээлэлд хяналт тавихыг хориглоход чиглэгдсэн байна. Өнөөдөр али-

ваа мэдээлэлд хяналт тавьдаг төрийн болон олон улсын байгууллага үгүй бөгөөд ХМХ-үүд нийтэлж нэвтрүүлж байгаа мэдээллийнхээ агуулгад өөрсдөө хяналт тавьдаг.

Харин электрон агуулгын хүрээнд тодорхой бие даасан хууль байхгүй ба энэ талаар хууль эрх зүйн орчин хараахан бүрдээгүй

гэж үзэж болно. Эрт үед хүмүүсийг алт мөнгө хэр ихтэйгээр нь хэмждэг байсан бол өнөөдөр тэднийг мэдээлэл хэрхэн олж авч, ажил амьдралдаа хэрхэн ашиглаж байгаагаар хэмжиж байна. Энэ хэмжүүрийн гол эх үүсвэр нь мэдээллийн асар их багтаамж, шуурхай хэлбэрийн цогц болох интернет юм. Гэтэл Ази тивийн хүн амын 70 гаруй хувь нь хөдөө орон нутагт амьдарч байна. Хөгжиж буй ихэнх орнуудын хөдөөгийн хүн амын амьдралын төвшин доогуур, хот хөдөөгийнхний мэдээллийн хэрэглээ эрс ялгаатай байна. Манай улсын хувьд нийт хүн

амын гуравны хоёр нь хотод амьдардаг, газар нутгийн хэмжээ уудам, хүн амын нягтшил багатай зэргээс хамаарч мэдээллийн хэрэглээ, шаардлага мөн адил ялгаатай байна. Нэг хэсэг нь буюу төв суурин газруудын ихэнх нь компьютер, интернетийг амьдралдаа өргөн хэрэглэдэг байхад зарим нь энэ талаар сонсоо ч үгүй байна. Тийм учраас мэдээллийн технологийн эрин үед түүний эерэг болон сөрөг үр дагаварыг

судлан дүгнэсний үндсэн дээр дараагийн алхмыг тодорхойлох ёстой юм. Дэлхий нийтийн технологийн дэвшлийг дагаад манай улс мөн адил мэдээлэл харилцааны шинэ шинэ техник хэрэгсэл, технологийг ашиглаж, хүмүүсийн өдөр тутмын амьдралд амжилттай нэвтрүүлж байгаа билээ. Саяхныг хүртэл эн-

«

Манай улсын хувьд нийт хүн амын гуравны хоёр нь хотод амьдардаг, газар нутгийн хэмжээ уудам, хүн амын нягтшил багатай зэргээс хамаарч мэдээллийн хэрэглээ, шаардлага ялгаатай байна. Төв суурин газруудын ихэнх нь компьютер, интернетийг амьдралдаа өргөн хэрэглэдэг байхад зарим нь энэ талаар сонсоо ч үгүй байна.

»

гийн харилцааны хэрэгсэл болох телефон утасны хувьд гэхэд л үйлчлэх болон хамрагдах хүрээ хязгаарлагдмал, хэрэглээний өртөг харьцангуй үнэтэй байсан бол өнөөдөр хүссэн цагтаа дуртай үедээ хаана байгаагаас үл хамааран телефон утас, хөдөлгөөнт холбоо, интернет үйлчилгээг ашиглан газар зүйн байршилд баригдалгүйгээр дэлхийн хүмүүстэй харилцаа тогтоож, электрон шуудангаар хэдхэн хоромын дотор захидал, бичиг баримт солилцож, интернетийн үйлчилгээг ашиглан, хэрэгцээтэй мэдээллээ камерын ард суугаад цаг алдалгүйгээр олох гэх мэт

өргөн хүрээ, боломж бүхий мэдээллийн орчинд хөл тавьж байна. Гэвч аливаа юмс үзэгдэл, техник хэрэгсэл бүхэн сайн болон саар талын аль алиныг өөртөө агуулж байдаг учир технологийн дэвшлийн зэрэг талыг нь хөгжүүлж, гарч болзошгүй сөрөг үр дагавараас нь аль болох зайлсхийж чадвал эдгээр дэвшилтэт техник, технологи нь бидний амьдралд үлэмж их ач холбогдол, үр нөлөөгөө өгөх юм. Энэхүү дэвшлийг ашиглан түгээж байгаа электрон мэдээлэл бидний амьдралд яаж тусаж байна вэ? Үүнд дараах зүйлийг хамруулж болно.

Мэдээллийн эрс ялгаатай байдал. Монголчуудын хувьд интернетийн үйлчилгээнд хүссэн хүн бүр хамрагдаж мэдээлэл авах боломж хязгаарлагдмал биш боловч нөгөө талаар эдийн засаг, орчин, техникийн боломж зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан тэр болгон бүгд ижил төвшинд хандаж чаддаггүйгээс болоод мэдээлэлд ялгаатай байдал бий болдог. Энэ үзэгдэл айл гэр, албан байгууллага, сургууль, улс гүрэн, дэлхийн хэмжээнд янз бүрийн байдлаар илрэн гарсаар байна. Өнөөдрийн бидний жишээ болгон ярих дуртай АНУ-ын нийгэм дэх эдийн засгийн болон бусад ялгааг сүүлийн 20 жилд бий болсон шинэ үзэгдэл буюу мэдээллийн ялгаатай байдал улам гүнзгийрүүлж байна. Энэ нь компьютер эзэмшихтэй холбоотой. Нийгмийн чинээлэг хэсэг компьютер ашиглан оюуны хэрэгцээгээ нэмэгдүүлж амьдралаа дээшлүүлж байхад ядуу гэр бүлийн хүрээнд компьютергүй хэвээр байна. Харин энд нэг зүйлийг онцлон хэлэхэд 2005 оноос эхлэн Монголын Мэдээлэл, харилцаа, технологийн газраас зохион байгуулж буй "Өрх бүрийг компьютер-

тэй болгох аян" манай улсын ихэнх айлыг компьютержүүлэхэд ихээхэн хувь нэмрээ оруулж байгааг зориуд дурдууштай.

Энэ хүрээнд борлуулагдаж байгаа компьютер үнийн хувьд харьцангуй өндөр ч зээлээр болон лизингээр авах боломжтой байгаа нь тун сайн хэрэг юм. Гэхдээ дараах судалгаанаас монголчуудын мэдээллийн ялгаатай байдал илүү тод харагддаг. Тухайлбал, Инфокон компанийн явуулсан судалгаагаар дараах үзүүлэлт гарчээ⁵. Интернет хэрэглээний давтамж:

- Өдөр бүр 35% (хотод), 30% (хөдөө)
- Хэрэгтэй үедээ 15,3% (хот), 8% (хөдөө)
- 2-3 хоног тутамд 12,4% (хот), 12,4% (хөдөө)
- Хааяа 9,6% (хот), 7% (хөдөө)-тай байна.

Мэдээлэл олж авах байдлын тод ялгааг энэ судалгаанаас харж болно. Түүнчлэн нийслэл хотод оршин суудаг хүмүүсийн ихэнх нь буюу 38,5 хувь нь ажил дээр, 20 хувь нь гэрт, 2,8 хувь нь ажил болон гэртээ компьютерийг хэрэглэдэг ажээ. Тэгвэл интернет хэрэглэгч нийт хүмүүсийн 33 хувь нь ажлын байрандаа, 18,6 хувь нь интернет кафенд, 7,4 хувь нь гэртээ, үлдсэн 41 хувь нь ажил, гэр, интернет кафенаас холбогддог байна. Манай орны хувьд энэ мэт дэлхийн мэдээллийн сүлжээнээс хол хоцрох үзүүлэлт оршсоор байна.

Мэдээллийн нийгэм дэх орчны зөрчил. Интернет цаг хугацаа, орон зайн талаарх ойлголтыг үгүй болгодог. Нийгмийн мэдээлэлжүүлэлтийн жин өсөн нэмэгдэх тусам электрон

мэдээлэл хүрээгээ тэлсээр байна. Мэдээллийн энэ орон зай, нэг цаг хугацаанд дэлхийн бүхий л соёл, үнэт зүйл, үзэл санаа нь нийгмийн хүртээл болж таарах нь. Энэ онцлог нь мэдээлэлжсэн нийгмийн зөрчлийг үүсгэдэг. Бид өнөөдөр электрон шуудангаар захиа илгээх, вэб хаяг сонирхох зэрэг боломжоор хангагдсан. Гэтэл үүнээс илүүгээр технологи ашиглан олон үйлдэл хийж чадах хэмжээнд хүрэх шаардлага тавигдаж байна.

Баримт дурдахад Монголд өнөөдөр 1000 гаруй вэб сайт байдгийг агуулгаар нь ангилан судалсан байна. Жишээ нь: иргэний нийгэм 19.4, бизнес санхүү 12.3, аялал жуулчлал 11.7, шинжлэх ухаан, технологи 9, урлаг спорт 8.9, төр засаг 8.7, боловсрол 6.7, хэвлэл мэдээлэл 8.3, онлайн үйлчилгээ 2.6, байгаль орчин 1.2, улс төр 0.7, хүүхэд гэр бүл 0.4, бусад төрлийн вэб 6.7 хувийг эзэлж байна. Гэтэл хөдөө орон нутагт: Баянхонгор, Өмнөговь, Дархан-Уул гурван аймгийн 80 байгууллагаас 88,8 хувь нь компьютертай, 35,4 хувь нь интернет холболттой, 34,6 нь электрон шуудангийн хаягтай, 21,4 вэбтэй, 28,2 нь дотоод сүлжээтэй байна. Мөн 20 хүний дунд нэг компьютер оногддог. Компьютерийг 81,9 хувь нь ажил хэргээ хөтлөхөд, 37,7 нь интернет ашиглахад, 32,2 нь хувийн тооцоолол хийхэд ашигладаг байна. Тэгвэл интернетийг 84 хувь нь мэдээлэл авах-түгээх, 74.1 нь мэйл солилцох, 32.4 нь программ татаж авах, 30 нь утсаар ярих, факс ашиглах зорилгоор хэрэглэдэг ажээ.

Дээрх үзүүлэлт бол манай нөхцөлд тийм ч чамлахаар зүйл биш. Харин сөрөг тал нь юу вэ гэвэл мэдээлэл авах нэрийдлээр бид техник

хэрэгслийн орчинд уусаж байна. Хамгийн наад захын жишээ бол арван жилийн хүүхдүүд компьютерийг зөвхөн тоглох зорилгоор, интернетийг ердөө л чатлах, эсвэл элдэв бусын ямар ч үр ашиггүй сайт руу орох байдлаар ашиглаж байна. Томчуул ч хэлний бэрхшээлээс болоод тэр болгон ашигтай мэдээлэл авч чаддаггүй учраас элдэв янзын порно сайт үзэх гэх мэтээр цаг нөхцөөж байна.

Хэт их мэдээлэл нь бичгийн соёлд нөлөөлөх үү? Электрон мэдээллийг нийтэд түгээх гол хэрэгсэл болсон интернетийн сүлжээгээр дамжин "chat" буюу чалчих байдлаар ихэвчлэн авч байна. Үүнийгээ ихэнх хүн мэдээлэл солилцох зорилготой гэж тайлбарладаг ч түүнээс ажил амьдралд нь хэрэг болохуйц мэдээлэл тун цөөхөн билээ. Наад захын жишээ дурдвал, чатаар харилцахдаа латин үсэг ашигладаг. Тодорхой нэг тогтсон үг зүйн болон үсгийн дүрэм байхгүйгээс латин үсгийг хүн бүр өөрийн үзэмжээр хэрэглэж байгаа нь монгол хэлний яриа, бичгийн соёл алдагдахад хүргэж байна. Мөн мэдээлэл солилцох энэ "онцгой хэлбэр"-т ажил, гэр гэсэн зааг арилж, байр нь солигдож байна. Хүмүүс бодох, тунгаах шаардлагатай ажлаа хэн ч саад хийж болохгүй гэртээ хийхийг хүсдэг ба ажил дээрээ зөвхөн чатлаж байна. Өөрөөр хэлбэл мэдээллийн энэ хэлбэр, техникээр дамжуулан холбогдож буй энэ харилцаанаас болж хүн гэдэг "амьтан"-ы үнэ цэнэ алдагдахад хүрч байна.

Хүн, эсвэл Компьютер. Хүсээгүй мэдээллийг хүчээр өгөх. Дэлхий дээр хамгийн ухаантай нь хүн биш, компьютер гэсэн хандлага ноёлж байгаа өнөө үед интернетийн хөгжил эхлэлийн

шатандаа яваа манай орны хувьд энэ тал дээр санаа зовох бага боловч хойч үеийнхэн маань тоглож буй тоглоомдоо хэт автах, телевиз, кабелийн сувгуудаар гарч буй хэт техникжсэн мэдээлэлд үнэмших, түүнийг маш үнэ цэнэтэй зүйл мэтээр хүлээж авч байна. Хүн төрөлхтөн интернет ашиглаж өөр хоорондоо холбоо тогтоосноор өдөр болгон санал бодлоо солилцох, үзэж харснаа хуваалцах зэрэг өндөр боломж нээгдсэн.

Зөвхөн компьютер ч бус, хөдөлгөөнт утсаар мэдээлэл авч болдгийг Япон, АНУ гэх мэт орны жишээнээс харж болно. Америкийн "IDC" компанийн судалгаагаар хөдөлгөөнт утас ашиглалт нь компьютерийн тархалттай харьцуулахад 3 дахин их гарчээ. Энэ нь тухайн утаснууд тооцоолох үйлдэл, өгөгдөл дамжуулах боломжтой болсонтой холбоотой юм. Манай орны хувьд хөдөлгөөнт утсаар мэдээлэл авах нь бүү хэл гэртээ компьютертай айл нийт хүн амын тун цөөхөн хувийг эзэлдэг билээ. Маш цөөн хэсэг нь гэрийнхээ компьютерт интернет холбуулсан байдаг. Дээрх жишээнүүдийг дурдахын учир технологийн хөгжлөө дагаад нийгмийн шинэ "бэрхшээл" болох хүсээгүй мэдээллийг хүчээр өгөх байдал ажиглагдаж байна. Сонин хэвлэл, радио, телевиз, компьютер, гар утас, интернет нь хүмүүсийг мэдээллээр "бөмбөгдөж" эхэллээ. Эцсийн дүндээ хүмүүс мэдээллийн үнэн бодит байдал, ач холбогдлыг ялгах аргагүй байдалд орж,

зэрэгцсэн олон мэдээллийн нөлөөллөөс зугтаж, зарим тохиолдолд эргээд нөгөө мэдээллээсээ уйдаж байна. Өөрөөр хэлбэл хүн төрөлхтөн өөрийн мэдээлэл хүлээн авах хүслээс үл хамааран техник технологийн эрхшээлд орж байна.

Мэдээллийн хамгаалалт. Электрон мэдээлэлтэй уялдаад түүний аюулгүй байдал, хамгаалалтын асуудал зайлшгүй яригдана. Тухайн мэдээллийг

электрон хэлбэрээр тарааж байгаа вэб сайт, байгууллагын сүлжээний администраторууд энэ асуудлыг хариуцах ёстой боловч тэдний мэдлэг, чадварын хэмжээ, ажлын туршлага дэндүү дутмаг. Энэ нь Монголын нийгмийн нөхцөл байдалтай,

«

Манай орны хувьд хөдөлгөөнт утсаар мэдээлэл авах нь бүү хэл гэртээ компьютертай айл нийт хүн амын тун цөөхөн хувийг эзэлдэг билээ. Маш цөөн хэсэг нь гэрийнхээ компьютерт интернет холбуулсан байдаг.

»

мөн шинэ тутам хөгжиж буй Мэдээлэл, холбоо, технологийн салбарын үйл ажиллагаатай нөгөө талаар холбоотой. Бидний үлгэрлэн дуурайдаг АНУ-д хэн ч хаанаас ч ямар ч мэдээллийг электрон хэлбэрээр авах боломж өндөр байдаг нь эргээд тухайн иргэний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлдөг байна. Өөртөө хэрэгтэй мэдээллийг тухайн хүн компьютертаа хадгалдаг ч эрчим хүчний өөрчлөлт, буруу хэрэглээ, компьютерийн вирус гэх мэтээс мэдээллээ алдах аюултай. Түүнээс гадна мэдээллийн хамгаалалтын асуудалд хувь хүний техникийн мэдлэг, компьютер ашиглах чадвар бас яригдах юм. Техникийн онцгой эвдрэл биш бол хатуу диск дээрх мэдээллийг сэргээж болох ч хүмүүсийн техникийн

мэдлэг дутмагаас ихэнхдээ мэдээллээ алдахад хүрдэг. Ингээд тусгай мэргэжилтэн шаардагддаг. Дүгнэвэл, мэдээллийг хурдан шуурхай, хүртээмжтэй хүлээн авах энэхүү электрон хэлбэр нь технологийн хэт дэвшилтэй уялдаад эргээд сөрөг нөлөө үзүүлдэг байна.

Дүгнэлт

Ер нь түүхэн янз бүрийн үед технологийн дэвшлийг эсэргүүцдэг хүмүүс байсаар ирсэн ба бид шинэ дэвшил, өөрчлөлтийг үг дуугүй дэмжиж, сайн мууг нь мэдэхгүй хошуурахаас өмнө аливааг олон талаас нь эргэцүүлж, цэгнэж байх шаардлагатай гэдэг үүднээс дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1. Юуны өмнө электрон мэдээлэл бол шинэ технологи дагаж гарч ирсэн үр өгөөжтэй атлаа сөрөг тал ихтэй үзэгдэл болохыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Үүнийг зохицуулах үүрэгтэй Мэдээллийн технологийн хуулийн төсөл хэлэлцэгдээд бэлэн болсон юм билээ. Батлагдахаас нь өмнө электрон мэдээллийн сөрөг үзэгдлүүдийг судалж, анхнаас нь зөв эхэлбэл цаашид гарах сөрөг хандлага ч тодорхой хэмжээгээр багасах юм.

2. Гэхдээ төрийн дэмжлэг хараад байлгүй сүүлийн арваад жилийн хугацаанд бий болгосон электрон агуулгыг бүрдүүлж байгаа мянга гаруй вэб сайт дахь мэдээллийг байнга шинэчилдэг байвал хувь хүмүүсийн үнэн зөв мэдээлэл авах боломж нэмэгдэж тэр хэрээр интернетийг зөв, үр дүнтэй ашиглах боломж бүрдэнэ.

3. Бодит мэдээлэл цаг хугацаа алдахын аргагүй, амин чухал хэрэгцээ байдгийг бид анзаардаггүй. Тиймээс

интернетийг оновчтой ашиглаж сурах талаар хувь хүн, энэ салбарынхан, цаашлаад төр засаг ажил хийх хэрэгтэй. Тухайлбал, хувь хүний хувьд энэ талаарх сурталчилгааг сайн хийх нь зөв. Жишээ нь, интернет бол зөвхөн чалчих, захиа солилцох, ажлын бүтээмжээ алдаж порно сайт үзэх хэрэгсэл биш, харин мэдээллийн арвин их далай юм шүү гэдгийг мэргэжлийн үг хэллэгээр бус, хүн бүрт ойлгомжтойгоор, мөн ойр дөт байдаг зүйлээр нь дамжуулан сурталчлах.

4. Электрон мэдээллийн эх ундарга Интернетийг хөдөө орон нутагт сурталчилах, хөгжүүлэхэд энэ салбарын мэргэжилтнүүдээс гадна оюутан залуусыг дайчлах. Тухайлбал, ийм чиглэлийн томоохон байгууллагатай гэрээ хийж, оюутны амралт болоод аялал, дадлагын үеэр хөдөө аж ахуй, газар зүй аялал жуулчлал, программ хангамж, гадаад хэл, сэтгүүл зүй, зураглаачийн ангийн оюутнуудаас сонгон авч аймгуудад явуулж интернет мэдээллийг сурталчилж болно.

Хавсралт

Электрон мэдээллийг дамжуулж байгаа хамгийн идэвхтэй хэлбэр бол манай орны хувьд вэб сайтууд байгаа. Тэдгээр вэб сайтын талаарх мэдээллийг хавсаргалаа.

- Монголд өнөөдрийн байдлаар мянга гаруй вэб сайт байдаг.

- Нийт вэб сайтын 73,6 хувь нь ".mn" домэйн нэрээр, дотоодын интернетийн үйлчилгээ үзүүлэгч (ISP) компаниудын сервер дээр байрлаж байна. Мөн .com, .org, .net домэйн нэрээр байрладаг.

- Нийт вэбийн 50,4 хувь нь хувийн хэвшил, 30,7 хувь нь олон нийтийн болон ашгийн бус байгууллага, 9,8 хувь нь хувь хүмүүс, 9,1 хувь нь төрийн байгууллагад харьяалагддаг байна.

- Монгол хэлээр 36 хувь, англи хэлээр 33 хувь, 28,2 хувь нь хоёр хэлээр, 2,8 хувь нь гурав ба түүнээс дээш хэл дээр вэб хуудсаа хийжээ.

- Шинэчлэлтийн хувьд нийт вэбийн дөнгөж 2 хувь нь динамик бүтэцтэй бөгөөд бусад вэб шинэ мэдээллээр баяжих нь бүү хэл зөвхөн танилцуулга төдий зүйл байна.

Ишлэл

¹ 2001. Монгол улсын Ном хэвлэлийн хүрэлцээ, хангамж Засгийн газрын санал зөвлөмж. БСШУЯ, УБ.

² 2002. "Монголын хэвлэл мэдээллийн мониторинг" төслийн тайлан. МХХ, УБ.

³ Мөн тэнд.

⁴ 2003. Монгол улсын Мэдээлэл холбоо технологийн хөгжлийн өнөөгийн байдал. УБ., 31 дэх тал.

⁵ Мөн тэнд. УБ., 2003. 33 дахь тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. 2001. Монгол Улсын Ном хэвлэлийн хүрэлцээ, хангамж, Засгийн газрын санал зөвлөмж. БСШУЯ, УБ.
2. 2002. "Монголын хэвлэл мэдээллийн мониторинг" төслийн тайлан. МХХ, УБ.
3. 2003. Монгол улсын Мэдээлэл холбоо технологийн хөгжлийн өнөөгийн байдал. УБ.
4. 2004. Интернет, вэб сайтын нэвтэрхий толь. УБ.
5. www.google.mn
6. www.sonin.mn
7. www.ict.mn/midas/
8. www.tsahim.net
9. www.olloo.mn
10. www.forum.mn.

Резюме

В данной статье автор раскрывает сущность электронной информации в современном информационном обществе. В последние годы электронные СМИ всё более и более укрепляют свои позиции в общей системе информационных средств. Однако недостаточная плотность и жизненный уровень населения, необъятная территория и др. факторы всё ещё закрывают для большинства населения доступ к электронным СМИ.